

“Баян-Уул” ХК-ийн хувьцааг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, “Баян-Уул” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“Баян-Уул” ХК-ийн нийтэд санал болгож гаргасан 154387 ширхэг хувьцааг бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Хувь нийлүүлэгчдийн хурлаас компанийг өөрчлөн зохион байгуулах шийдвэр гаргахад оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах эрхийг хэрхэн хэрэгжүүлсэн тухай тайланг 2008 оны 8 дугаар сард багтаан Хороонд ирүүлэхийг “Баян-Уул” ХК /Гүйцэтгэх захирал С.Сумьяа/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын талаар Үндэсний татварын ерөнхий газрын харьяа Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ